

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Зэндмэнийн Аюурзана	Дугаар	L114
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Батноров сум
Төрсөн газар	Хэнтий аймаг Батноров сум	Төрсөн он	1914
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Сүжигт бэйсийн хүрээ, Үзэмтийн хийд	Сүм хийдийн дугаар	ХЭБВ 112, ХЭБВ 111
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 18	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



СҮЖИГТ БЭЙСИЙН ХҮРЭЭ ҮЗЭМТИЙН ХИЙД

-Бат-Өлзийтийн энгэрт нэг дуган байдаг штээ? Тэрнээс ондоо жижиг тийм дуган байсан юм уу?

Нэг дугантай байсан.

-Та хэр багцааны лам нартай байсныг нь мэдэж байна уу?

Мэдэхгүй.

-Олон байсан уу? Цөөхөн байсан уу?

Цөөхөн ламтай байсан. 10 хүрч байсан болов уу даа.

-Энэ Бат-Өлзийтийн хийд хэдэн дугантай байсан юм бэ?

Нэг л дугантай байсан.

-Замын үрд нэг туурь байсан. Тэр юуны хийд юм болоо?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мэдэхгүй. Ялгуусан ламын хийд л гэдэг байсан. Ялгуусан лам 5 насандаа энд ирж ном тавьж байсан. Би мэднэ. Би сууж байсан юм. Одоо энэ сүм байгаа дээр л тавьж байсан байх. Ялгуусаны хийд л гэдэг байсан. Тэр ламд зориулж хийсэн.

-Хэдэн оны үед байгуулагдсан юм бол?

Мэдэхгүй.Намайг 5 настай байхад л тэр Ялгуусан лам ирж лам нар цуглаж байсан.

-Төвд нэрийг нь юу гэдэг байсан юм бол?

Мэдэхгүй.

-Ямар хуралтай байсан бэ?

Мэдэхгүй. Ганжуур, Данжуур гэж байдаг байсан. Боодолтой их олон номнууд.

- Энд Майдар эргэдэг байсан уу?

Майдар бол эргэдэггүй байсан.

-Сахиус нь ямар сахиус байсан юм бол?

Лхам сахиус гэж байсан байхаа. Баруун хийд чинь Махагал сахиустай байсан. Энэ нь Лхам байх аа. Хамба лам гэж байсан. Тэрний өргөөний суурь гэж байсан. Тээр зүүн хойд хамар дээр гэрийн буурь нь байдагсан. Одоо байхгүй болсон уу. байхгүй болоо биз дээ. Цөөхөн ламтай байсан. Залуу лам нар цөөхөн. Дандаа настай лам нар байсан.

-Хамба ламын нэр хэн бэ?

Хэн гэдэгсэн билээ. Дамба гэдэг байсан байхаа. Дамба гавж гэдэг байсан. Цөөхөн лам нартай цөөхөн байшин савтай жижиг хийд байсан юм.

-Ямар шашны хийд байсан бэ? Улааны урсгал уу, шарын урсгал уу?

Би сайн мэдэхгүй.

-Энд лүйжинч, зодоч нар хүрж байсан уу?

Мэдэхгүй тэрийг. Улсууд энэ хийдийн Ганжуурын 108 боть их эргэхэд их ирдэгсэн.

-Сүжигтийн хийд хэдэн дугантай байсан бэ?

Оо мэдэхгүй. 3,4 дугантай байсан байхаа. Манбын дуган л гэдэг. Гол дуган л гэдэг. Бурханаа залдаг дуган л гэдэг. Нэлээн дугантай байсан байх. Олон л дуган харагдаж байсан. Олон дуган байсан.

-Хэр олон ламтай байсан бэ?

Харин олон лам нар байсан. Хар болох нь болоод бараг нь баригдаад явчихсан биз дээ.

-Голлох хурлууд нь ямар хурлууд хурдаг байсан бол оо?

Майдар эргэдэг байсан. Ерөөл энэ тэр хурдаг л байсан. Хайлан хурдаг байсан.

-Урд хийд хайлан хурах уу?

Үгүй ээ тэгж сонсоогүй.Энэ баруун хийд чинь л хайлантай байсан.

-Сүжигтийн хийдийн мяндагтангуудыг мэдэх үү?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гунгаа лам гэж хамба лам нь байсан. Гэсгүйгийн нэрийг санахгүй байна. Сүүл үедээ Шарав лам нэг хамба нь байсан. Хотод хийдэд сууж байсан Алтангэрэл гэж хүн бий. Тэр л мэднэ дээ. 80 гарч байгаа. Банзрагчийн Алтангэрэл гээд. Тэр л энэ хоёр хийдийн аль алинд нь сууж байсан байх. Гайгүй мэднэ.

-Дугануудыг ямар материалаар барьсан юм бол?

Тэрийг мэдэхгүй ээ. Залуу байсан болохоор анхаарч явсангүй.

-Хийдүүд хаагдсанаас хойш сүм дуганы барилгуудыг яасан юм бол?

Баруун бригадын тэнд машинтай олон оросууд нураагаад хаячихсан. Урд голын тохой дүүрэн балгас болсон.

Модон дуганууд л байсан байх. Урд хийд бас мод байсан байх. Баруун хийд харин тоосгон дуган байсан байх.

Энд бол тоосгон дуган байгаагүй.